

"БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ
(2023-2024 он)

2023.12.10

Дархан-Уул аймаг

№	Бодлогын үндэслэл (Альсын хараа-2050)	Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2023 оны зорилтот түвшин	2023 оны хэрэгжилт	Хэрэгжилт хувь
1		Зорилт 1. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох					
1		Үйл ажиллагаа 1.1 Соёлын боловсрол олгох албан бус сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулах	Хөтөлбөр, агуулгын тоо, хөтөлбөрт хамрагдсан хүний тоо	Музейн боловсролын хөтөлбөр-8, Соёлын боловсролын сургагч багшийн анхан шатны хөтөлбөр-1	Сургалтын хөтөлбөрийн тоог 2-оор нэмэгдүүлэх	<p>Дархан-Уул аймгийн Музей нийт 13 боловсролын хөтөлбөрийг 204 удаа зохион байгуулж 28102 иргэдийг хамруулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Музейгээс "Мандала", "Мартан", "Нагтан", "Оюуны цэнгэл", "Оюуны зангилаа", "Уран зураг уншихуй", "Аав ээж би", "Бүтээлч гар", "Бяцхан гар", "Шинэ дурсамж", "Мэдлэгийн хурд" зэрэг 13 төрлийн боловсролын хөтөлбөрийг зохион байгуулсан. -Аймгийн Төв номын сан 2023 онд номын сангийн боловсролын 3 хөтөлбөрийг шинээр боловсруулан 55 удаа зохион байгуулж, 1014 сурагчийг хамруулсан. -Хүүхдийн номын ордон: "Угийн бичиг хөтлөх арга зүйд сургах" боловсролын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, нийт 17 удаагийн сургалтад 881 хүүхдийг хамруулсан. -Сумдын соёлын төвүүд нийт 400 гаруй хүүхдийг боловсролыг хөтөлбөрт хамруулсан. -Сургагч багш бэлтгэх сургалтыг 5 удаа зохион байгуулж 94 хүнийг хамруулсан. -МУУГЗ Г.Баяртай багшийн удирдлага дор бий биелгээний "Угсаатан бий" төслийн сургалтад 17 хүүхэд хамрагдсан. -Ахмад уран бүтээлч Б.Алтанцэцэг 12 хүүхдэд бий биелгээ, 2 хүүхдэд хурдан морины цол дуудах эрдэмд сургасан. -Аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг нэмэгдүүлэх, шавь сургалтыг уламжлал болгох зорилгоор "Өв соёлоо өвлөн уламжилъя" Зүү ороох хатгамлын сургалтад ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 20 сурагчийг хамруулан зохион байгуулсан. -2022.11.16-ны өдрийн 6/3074 тоот "Соёлын боловсролын үндэсний сургагч багш" бэлтгэх сургалтад аймгийн Төв номын сангийн Захирал Б.Цэцэгсүрэн хамрагдсан. -2023.09.13-ны өдрийн 8/2401 тоот "Бүх нийтийн соёлын боловсрол" хөтөлбөрийн хүрээнд МУ-ын СББӨ-ийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад аймгийн соёл, урлагийн газрын 2 албан хаагч хамрагдсан. Уг сургалтад хамрагдсан албан хаагчид 2023.11.20-ны өдөр Ахмадын хөгжлийн төвтэй хамтран соёлын ажилтнуудын дунд "Соёл ба оролцооны соёл" сургалтыг зохион байгууллаа. 	100%
2		Үйл ажиллагаа 1.2 Нүүдлийн соёлын боловсрол олгох жишиг хөтөлбөр батлах	Батлагдсан жишиг хөтөлбөрийн тоо	-	Хилийн чанад дах хүүхэд багачуудад зориулсан Нүүдлийн соёлын боловсрол олгох жишиг хөтөлбөр-1	Аймгийн Музей 10 боловсролын хөтөлбөрт 5841 иргэд, хүүхэд хамруулсан. Хүүхдийн номын ордон нь1 боловсролын хөтөлбөрт 3121 хүүхэд хамруулсан. Мөн нүүдлийн соёлын боловсрол олгох албан бус сургалтын хөтөлбөр боловсруулах саналыг ажилтан, албан хаагчдаас авч байна.	100%
3			Нүүдлийн соёлын боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх зуслангийн тоо	-	3	Соёлын байгууллагуудтай хамтран Зулзагын гол-Хүүхдийн зусланд амрагч 900 хүүхдүүдэд нүүдлийн соёлын боловсрол олгох зорилгоор "Монгол бахархал" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.	100%
4	1.2.3 1.4.1 1.1.15	Үйл ажиллагаа 1.5 Соёлын байгууллагын үйл ажиллагаа, уран бүтээлийн бодлогыг соёлын боловсрол олгоход чиглүүлж, хөтөлбөртэй байгууллагын тоог нэмэгдүүлэх	Соёлын боловсролын хөтөлбөр баталгаажуулсан байгууллагын тоо	50	Баталгаажуулсан хөтөлбөртэй байгууллагын тоо-70	Дархан-Уул аймгийн соёлын байгууллагууд болох Төв номын сан, Музей, Хүүхдийн номын ордон, сумдын соёлын төвүүд нийт 19 боловсролын хөтөлбөрийг зохион байгуулсан.	98%

5	Үйл ажиллагаа 1.6 "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах	Гаргасан санал, санаачилга, зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн	-	Хамтын ажиллагааг сайжруулах, хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах. 21 аймаг, 330 сум, 9 дүүрэгт чиглэл хүргүүлэх	Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Соёл, урлагийн газар харьяа соёлын байгууллагууд руу чиглэл хүргүүлж тайланг цаг тухай бүр авч холбогдох байгууллага руу хүргүүлж ажилласан. Мөн төрийн болон төрийн бус байгууллагууд журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж буйд хяналт тавьсан. Үүнд: 1.Соёлын боловсролын хүрээнд "Эх хэл түүх соёлоо эрхэмлэн дээдэлсэн, эрүүл чийрэг, эх оронч, бүтэлч Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд чиглэсэн 3 саналыг аймгийн ГБХМ-т хүргүүлсэн. Мөн төр, хувийн хэвшлийн байгууллагууд хүүхдийг орой үдшийн цагаар ажлуулах, ямар нэгэн арга хэмжээнд хүүхдийг оролцуулахад анхаарах зэрэг асуудлыг нэн түрүүнд анхаарч ажиллаж байна. 2.Хүүхдийн хөгжлийг дэмжсэн урлагийн тоглолтыг 42 удаа зохион байгуулж 17300 хүүхэд, 3.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нээлтээр 35 үйл ажиллагаанд 500 гаруй хүүхэд оролцож 1000 гаруй үзэгч, 4.Соёлын байгууллагуудын "Эцэг эхийн зөвлөл" нийт 48 нөлөөллийн ажил, 5."Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах" сургалтад 10 албан хаагч, 6."Тэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сургалтад 11 албан хаагч, 7.Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Айдсын ном" кино 4400 гаруй хүүхэд үзлээ. нээгдэх бүрт-хүргэх нэг үг", "Хүүхэд хөгжлийн хувийг бий болгох" уриан дор соёлын байгууллагууд нийт 89 арга хэмжээнд 35,218 /давхардсан тоогоор/ хүнийг хамруулж цахим орчинд 28 арга хэмжээг 45,699 хүнд, 9.Хүүхдийн хөгжил, хамгаалалд олон орлогоосоо 9,127,100 төгрөгийг зарцуулсан байна. 10."БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ" эх оронч үзлийг төлөвшүүлэх өдөрлөгт 712 сурагч, Дауны синдромоор дамжуулан олон нийтэд боловсрол олгох зорилготой "Трио" УСК-ны нээлтийг зохион байгуулсан. 11. Нэг дүгээрт хүүхэд аяны хүрээнд сумдын Соёлын төвд 11 дугуйланд 182 хүүхэд, 12.Залуучууд театр 42 удаагийн тоглолтыг 11 төрлийн дугуйланд 108 хүүхэд хамруулав. 13.Соёлын байгууллагууд 19 боловсролын хөтөлбөрийг 256 удаа зохион байгуулж 8614 хүүхдийг хамруулсан. 14.Соёлын салбарын Залуучууд хөгжлийн зөвлөлөөс 7 арга хэмжээ зохион байгуулав. Нийт 14 арга хэмжээ зохион байгуулж 67055 хүүхдийг хамруулсан.	100%	
2	Зорилт 2. Эко систем бүрдүүлэх						
6	1.2.5 1.2.8, 1.4.3, 1.4.6, 1.1.15 1.1.19	Үйл ажиллагаа 2.1 Соёлын боловсролын судалгаа хийх	Соёл, урлагийн боловсролын судалгааны тоо	5	ХБИ-ийн соёлын хэрэгцээг тодорхойлох судалгаа-1, Нэвтрүүлэг, контентын агуулгын мониторинг судалгаа-1, Нөхцөл байдлын судалгаа-1	Соёлын байгууллагууд нийт 7 удаагийн сэтгэл ханамжийн судалгаанд 2302 хүн хамруулж үйл ажиллагаандаа ашигласан байна. Үүнд: - Залуучууд театр нь уран бүтээлийн чанар төрөл, хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамжийн түүвэрчилсэн судалгаанд нийт 2000 үзэгч, - Төв номын сан Уншигчийн сэтгэл ханамжийн судалгаанд 50 уншигч, - Ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийн судалгаанд 50 уншигч, - Хүүхдийн номын ордон нь удаагийн сэтгэл ханамжийн судалгааг 4 удаа зохион байгуулж 202 сурагчийг тус тус хамруулсан. - "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Соёлын эрхийн бичгийн тандалт судалгаанд нийт 1209 сурагч судалгаанд хамрагдлаа. Хүрсэн түвшин: Соёлын байгууллагууд нийт 7 удаагийн сэтгэл ханамжийн судалгаанд 2302 хүн хамруулж үйл ажиллагаандаа ашигласан.	98%
3	Зорилт 3. Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах						
8	Үйл ажиллагаа 3.1 Соёлын боловсролын үндэсний сургагч багшийг бэлтгэх, мэргэшүүлэх	Сургалтын тоо Бэлтгэгдсэн үндэсний сургагч багшийн тоо	сургалт-1 Багш-60	Сургалт-2 Ахисан түвшинд-30, анхан түвшинд 30 багш бэлтгэх	-2023 оны 04 дүгээр сард аймгийн хэмжээнд ЮНЕСКО-ий яаралтай хамгаалах биет бус өв болох бие биелгээний сургагч багш бэлтгэх төслийн сургалтад 17 хүн хамрагдаж сертификат авсан. -2023 оны 09 сарын 18-20-ны өдрүүдэд ЮНЕСКО-той хамтарсан Соёлын өвийн боловсролын сургагч багшийн сургалтад соёл, урлагийн газраас 2 мэргэжилтэн хамрагдаж үндэсний сургагч багшийн сертификат авсан. 2022.11.16-ны өдрийн 6/3074 тоот "Соёлын боловсролын үндэсний сургагч багш" бэлтгэх сургалтад аймгийн Төв номын сангийн Захирал Б.Цэцэгсүрэн хамрагдсан.	100%	
9		Сургалтад хамрагдсан ЕБС-ийн багшийн тоо	Сургалтад хамрагдсан ЕБС-ийн багш-238 Эхний жил-155, Тав дахь жил-55, Арав дахь жил-38	352-оор нэмэгдүүлэх, Эхний жил-182, Тав дахь жил-115, Арав дахь жил-55	2023 оны хагас жилийн байдлаар Дархан-Уул аймагт бие биелгээний сургагч багшийн сургалтад хамрагдсан ЕБС-ийн багшийн тоо-19	100%	

10	1.4.1, 1.4.3+С19:К 36	Үйл ажиллагаа 3.2 Соёл, урлагийн боловсролын сургагч багш бэлтгэх, мэргэшүүлэх	Сургалтад хамрагдсан СӨБ-ын багшийн тоо	Сургалтад хамрагдсан СӨБ-ын багш-72	95-аар нэмэгдүүлэх	Бие биелгээний сургалтад хамрагдсан СӨБ-ын багшийн тоо-13	100%
11	Залуучуудын хөгжлийн төв, Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн сургалтад хамрагдсан мэргэжилтний хувь		0	15 хувьд хүргэх	Залуучуудын хөгжлийн төв, Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн 2 сургалтад 7 мэргэжилтэн хамрагдсан.	100%	
12	Сургалтад хамрагдсан хэвлэл мэдээллийн ажилтны тоо		70	50-аар нэмэгдүүлэх	-Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс зохион байгуулсан "Нийтийн мэдээллийн ил тод байдал, хувь хүний хөгжил" танхимын сургалт-1 хүн, -2023.08.29 Соёлын яам болон Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлөөс зохион байгуулсан "Хуурамч мэдээллийг таньж мэдэх, бодит байдлыг нягталж шалгах нь" цахим сургалт-6 хүн, -2023.01.30-31 Соёлын яамнаас зохион байгуулсан соёлын салбарын мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийг чадавжуулах сургалтад 1 хүн тус тус хамрагдлаа. Нийт 3 сургалтад 7 албан хаагч хамрагдсан.	100%	
4		Зорилт 4. Иргэдэд эерэг, бүтээлч хандлага төлөвшүүлэх, сургалт нөлөөллийн аян хэрэгжүүлэх					
13		Үндэсний бичиг соёл, номын өдрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний тоо, оролцогчдын хувь	Арга хэмжээ-186, Оролцогчид-220,000	Арга хэмжээ-190 Оролцогчдын тоог 5 хувиар нэмэгдүүлэх	Нийт хавар, намрын номын баяр, үндэсний бичиг үсгийн баярын 4 нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд 237 арга хэмжээг зохион байгуулж 34,539 хүнийг хамруулсан. Цахимаар 22,793 хүнд үйлчилгээг хүргэсэн байна.	98%	
14	Соёл, урлагийн сургалт дугуйланд хамрагдсан суралцагчийн тоо		Сургалт дугуйлан-2380 Сургалтад хамрагдагчид-38208	Сургалтын тоог 5 хувиар, Сургалцагчийн тоог 5 хувиар нэмэгдүүлэх	Залуучууд театр нь соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 11-н төлрийн дугуйлантай хамтран ажиллах гэрээ хийн ажиллаж байна. Үүнд: драмын дугуйлан - 2, дууны дугуйлан - 1, хөгжмийн дугуйлан - 4, бүжгийн дугуйлан - 3, циркийн дугуйлан 1 тус тус үйл ажиллагаа явуулж дугуйлануудад нийт 108 хүүхэд хамрагдан хичээллэж байна. Аймгийн Төв номын сан шатарын дугуйланг 12 удаа, Англи хэлний сургалтыг 9 удаа зохион байгуулж 77 хүүхдийг хамруулсан. Аймгийн Хүүхдийн номын ордон нь Төрөлжсөн 5 /Монгол хэл, бичиг-уран зохиол, Байгалийн ухаан, Гадаад хэл, Цахим ном-мэдээлэл, Book & coffee / танхимуудад давхардсан тоогоор 1373 хүүхэд үйлчлүүлж, 9024 ном хэвлэл болон хоцрогдол арилгах, бие даан суралцах давлага авах чиглэлээр үйлчилгээ авсан. Соёлын төв хүүхэд хөгжүүлэх 6 дугуйланд 160 хүүхэд суралцуулж, 2023 онд 88 удаа давхардсан тоогоор 1111 хүүхэд дугуйланд хамрагдсан байна. Орхон сумын Соёлын төв бүжиг, шатар, спорт, хөгжим, жудо бөх зэрэг 5 дугуйланд 150 хүүхэд, 30 насанд хүрэгчид тус тус хамрагдлаа. Хонгор сумын Соёлын төв нь 2023 онд 3 дугуйланд 68 /давхардсан тоогоор/ хүүхэд хамрагдсан. Сургалт, дугуйлан - 27, Сургалтад хамрагдагчид- 2917	100%	

15			Хүүхэд, өсвөр үеийнхэнд соёл, хүмүүжил, хайрлах, хүндэтгэх эерэг, бүтээлч хандлага төлөвшүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн цогц арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн тоо	Арга хэмжээ-6 багц Төсөл-19	Арга хэмжээг 10-аар, Төслийг 5-аар нэмэгдүүлэх	<p>Төсөл хөтөлбөрийн тоо-12. Үүнд:</p> <p>-MIND UPDATE" төслийн сургалтад 500 хүүхдийг оролцуулж зохион байгуулав.</p> <p>- Аймгийн Засаг даргын нэрэмжит "БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ" өдөрлөгийн хүрээнд урлагийн тоглолт, лекц илтгэл, урлагийн тоглолт, зэвсэгт хүчний болон музейн болон номын үзэсгэлэн зэрэг нийт 10 арга хэмжээнд 712 хүүхэд, -"Оюунлаг</p> <p>Дархан" хөтөлбөрийг 21 удаа зохион явуулж 1560 хүн хамрагдсан байна.</p> <p>"Соёлын түүчээ-330" төсөлд хамтран ажиллах тухай саналыг Соёлын яаманд 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 111 тоот албан бичгээр хүргүүлж тус төслийн хүрээнд сумдын Соёлын төвүүд болон "Тэнгэрийн" тал хамтран ажиллах гэрээг байгуулсан. -"Музейн тохижилт"-10сая төгрөг, Студийн тоног төхөөрөмж-20 сая төгрөгийн төслийг дэмжүүлэн Музейн төсөл хэрэгжих эхэлсэн. -"Цахим Дархан" төслийн хүрээнд "Маамуу" брэндтэй хамтран Дархан хотын бэлгэдэл баатар бүтээх, хотыг танилцуулах 2 ангит хүүхдийн анимэйшн бүтээх ажлын хэсэгт ажилласан.</p> <p>Соёл, урлагийг дэмжих санд "Цахим номын сан" төсөл 18,000,000 төгрөгийн төслийг хүргүүлсэн.</p> <p>-Ахмадын хөгжлийн төвтэй хамтран ажиллах чиглэлээр ахмад номын санчдын зөвлөн туслах үйлчилгээний "Ахмадын сургааль алт" 2 удаагийн 1,440,000 төгрөгийн төсөл, "Иргэдийн оролцооны соёл"-ыг төлөвшүүлэх нь" 360,000 төгрөгийн төсөл, -"Тохилог номын сан" төсөлд 10 сая, "Олон ястны бүжгийн хувцас" төсөлд 20 сая, "Музейн тохижилт" төсөлд 10 сая төгрөг, "Студийн тоног төхөөрөмж" төсөлд 20 сая төгрөгийн төслийг орон нутгийн төсвөөр шийдвэрлүүлэн хэрэгжүүлсэн. -Хонгор сумын Соёлын төвд "ҮЙЧҮҮР" тоглоомын тухай боловсролын хөтөлбөр гаргаж нийт 48 сурагчдад сургасан.</p> <p>хэмжээний тоо- 15 арга хэмжээг 55 удаа зохион байгуулж 4223 хүүхдийг хамруулсан байна.</p> <p>-"Угийн бичгээ хэрхэн хөтлөх вэ?" сэдвээр 6 удаа сургалт зохион байгуулж, 350 иргэн оролцов.</p> <p>- "Үлгэрээс үлгэрлээ" чанга уншлага, тойм яриаг бага насны хүүхдүүдийн дунд 16 удаа зохион байгуулж, 729 хүүхэд хамрагдав.</p> <p>-Уншигч хүүхдүүдийн бүтээл, номын тэмдэглэл үзэсгэлэнд 1200 хүүхдүүдийн бүтээл тавигдаж 1500 хүүхэд үзэж сонирхов.</p> <p>-"Оюунлаг Дарханчууд" өдөрлөгийн үеэр сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 13 удаа 1036 боть номоор гаргасан.</p> <p>"Зохиолч хүүхэд" сэдэвт зохиолч, яруу найрагчдын уулзалт 4 удаа зохион байгуулагдаж, 310 хүүхэд хамрагдсан байна.</p> <p>"Уран жиргээ-2023" уран уншлагын уралдаанд 57 хүүхэд, "Бид эх орны ирээдүй" өдөрлөгөөр "АХА" тэмцээнийг ахлах ангийн 102 сурагчдын дунд зохион байгуулав.</p> <p>"Судар-Эрдэнэ" богино өгүүллэгийн уралдаанд ЕБС-ийн ахлах, дунд, бага ангийн болон СӨБ-ийн 82 хүүхэд оролцсон.</p> <p>2023 онд Төв номын сан боловсролын 3 хөтөлбөрийг шинээр боловсруулан 55 удаа зохион байгуулж, 1014 сурагчийг хамруулан байна. -"Угсаатан бий" төслийн бий биеллэний сургалтад 17 хүүхэд, "Журуун хүүхэдэйн үлгэр"-ийн уралдаанд 62 хүүхэд, Номын сангийн чиглэлээр хүүхдийн оролцооны INDEPOS MAKERS сайн дурын байгууллагыг шинээр байгуулж, хүүхэд, залуусруу чиглэсэн олон арга хэмжээг зохион байгуулсан.</p>
16	1.2.1, 1.2.3, 1.4.2, 1.5.2, 1.5.8, 2.1.20,	Үйл ажиллагаа 4.1 Хүний хөгжлийн үечлэл бүрд чиглэсэн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулах	Залуучуудад эерэг, бүтээлч хандлага төлөвшүүлэх, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний тоо	4 багц арга хэмжээ	Арга хэмжээг 5-аар нэмэгдүүлэх	<p>Аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөл нь тайлант онд нийт 7 арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үүнд:</p> <p>1. 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр тус аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөл оны анхдугаар хурлаа хийж зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулав. Тус онд улирал бүр нийт 4 удаагийн хурлыг зохион байгуулж ажиллав. 2. СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг нэмэгдүүлэх, шавь сургалтыг уламжлал болгох зорилгоор "Өв соёлоо өвлөн уламжилья" Зүү ороох хатгамлын сургалтад ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 20 сурагчийг хамруулан зохион байгуулсан. 3. Darkhan dance festival" анхдугаар бүжгийн уралдааныг зохион байгуулахад нь 5,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус тэмцээнд 18 багийн 300 гаруй сурагч оролцов.</p> <p>4. Нийт 5 удаагийн уран зургийн болон бүтээлийн цуврал үзэсгэлэнг толилуулав. Үүнд: -"Монгол авдар"-ны үзэсгэлэнг Эмэгтэйчүүдийн ордонд 7 хоног, - Зураач С.Мөнгөнзулын уран бүтээлийн "ГҮНЖ" үзэсгэлэнг Эмэгтэйчүүдийн ордонд 10 хоног, - Дарханы зураач урчуудын эвлэлийн 22 уран бүтээлчдийн "Мэдэрэмж" уран зургийн үзэсгэлэнг Залуучууд театрт 5 хоног, - Зураач Б.Жаргалсайхан "ART OF N" уран бүтээлийн үзэсгэлэнг 54 бүтээлээр 7 хоног, - D-art урлагийн багш, залуу зураач Ч.Нарангарав зураач хүүхдүүдийн бүтээлээр 3 хоног үзэсгэлэн гаргаж бүтээлийн дээжээс Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасагт бэлэглэлээ. - ЕБС-ийн сурагчдын дунд "Кинонд ээлтэй хот-Дархан" сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулсан. 5. Шарын гол суманд залуучуудад зориулсан өдөрлөг, цугларалтыг зохион байгуулж залуусын дуу хоолой, санал санаачилгыг шийдвэр гаргах түвшинд хүргүүлсэн.</p> <p>6. Дархан хотын уламжлалт соёлын арга хэмжээг бий болгох зорилгоор Дархан хотноо үйл ажиллагаа явуулж буй болон Дархан хотоос гаралтай хамтлаг, дуучдыг нэгтгэсэн тоглолтыг зохион байгуулав.</p> <p>7. D- art продакшн, Дархан-Уул аймгийн Дуучдын зөвлөлтэй хамтран сан байгуулах ажлыг эхлүүлсэн.</p>

17			Гэр бүлд чиглэсэн соёлын боловсролын хөтөлбөр, арга хэмжээний тоо	Гэр бүлийн боловсролын хөтөлбөр-8 Амьдрах ухааны хөтөлбөр-11 Эерэг хандлагын хөтөлбөр-1	Хөтөлбөр, арга хэмжээ-2	<p>Гэр бүлийн боловсролын хөтөлбөр-2 Амьдрах ухааны хөтөлбөр- 8 Эерэг хандлагын хөтөлбөр- 5 Арга хэмжээ- 20</p> <p>Соёл, урлагийн газар: Хүүхэд, гэр бүл, залуучуудад: 1.Соёл, урлагийн "Эцэг эхийн зөвлөл" газрын пэйж хуудсаар дамжуулан 18 нөлөөллийн ажил, 2."Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах" журмыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтад-11 хүн, 3.-"Хөшиг нээгдэх бүрт-хүргэх нэг үг", "Хүүхэд хөгжлийн хувийг бий болгох" уриан дор соёлын байгууллагууд нийт 89 арга хэмжээнд 35,218 /давхардсан тоогоор/ хүнийг хамруулж цахим орчинд 28 арга хэмжээг 45,699 хүнд, Хүүхдийн хөгжил, хамгаалалд олон орлогоноосоо 9,127,100 төгрөгийг зарцуулсан байна. 4."БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ" эх оронч үзлийг төлөвшүүлэх нээлтийн өдөрлөгт 500 сурагч оролцож, тус өдөрлөгийн хаалтын үеэр Тусгай байр эзэлсэн 13 хүүхдүүдэд гарын бэлэг гардуулсан. 5. Дауны синдромоор дамжуулан олон нийтэд боловсрол олгох зорилготой "Трио" уран сайхны киноны нээлтийг зохион байгуулсан. 6.Нэг дүгээрт хүүхэд аяны хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилд сумдын соёлын төвд 11 дугуйлангийн 182 хүүхэд хичээллэсэн. 7."MIND UPDATE" төслийн сургалтад 500 хүүхдийг хамруулсан. 8.Аймгийн Музей нь "Мандала", "Мартан", "Нагтан", "Оюуны цэнгэл", "Оюуны зангилаа", "Уран зураг уншихуй", "Аав ээж би", "Бүтээлч гар", "Бяцхан гар", "Шинэ дурсамж", "Мэдлэгийн хүрд" зэрэг 13 төрлийн боловсролын хөтөлбөрийг 218 удаа зохион байгуулж 24323 иргэдэд хүргэж ажилласан. 9.Соёлын байгууллагууд Зохиолч, уншигчдын уулзалт, шинэ шилдэг номын үзэсгэлэн худалдаа, сурталчилгаа зэрэг соён гэгээрүүлэх олон талт 28 арга хэмжээг зохион байгуулж 15631 иргэдийг хамруулсан байна. Нийт 3 сэдвийн хүрээнд 20 арга хэмжээ, 18526 хүн хамрагдсан байна.</p>	100%
18			Ахмад настанд чиглэсэн соёлын арга хэмжээний тоо, оролцооны хувь	Арга хэмжээ-28 Оролцоо-44,000	Арга хэмжээ-15 Оролцогчдын тоог 2 хувиар нэмэгдүүлэх	<p>Аймгийн Музей Цагаан сарын баярыг тохиолдуулан 1, 8 дугаар багийн 16 ахмадыг урьж уламжлалт тоглоом наадгайг сурган, түгээн дэлгэрүүлэв. Мөн Ахмадын хөгжлийн төвд "Уламжлалт тоглоом наадгай" боловсролын хөтөлбөрийг зохион байгуулж 36 ахмадыг хамруулав. Нийт 56 ахмадад үйлчилсэн байна. -Соёлын Биет ба Биет Бус Өвийн тухай мэдлэг боловсролыг дээшлүүлэх, Ардын уламжлалт тоглоом наадгайг сургах, сурталчлан таниулах зорилгын хүрээнд "Үйчүүр" боловсролын хөтөлбөрт Ахмадын хөгжлийн төвийн 36 ахмад настанг хамрууллаа. Хүүхдийн номын ордон Ахмад настан 14, хөгжлийн бэрхшээлтэй 35, тусгаарлах байрны 12 уншигчид үнэ төлбөргүй карт нээж, зөөврийн номын сангаар 6 удаа 150 боть номоор үйлчилгээ үзүүлсэн. Өндөр настан 5 уншигчдад гэрээр ном олгох үйлчилгээгээр 11 удаа 19 боть ном хүргэж ажилласан. Шарынгол сумын Соёлын төв "Бурханд хаягласан захидал", " Сар шинийн баярт - Ерөөл дүүрэн монгол", "Шилдэг буянтай ээж" арга хэмжээг зохион байгуулсан. -Сумын ахмад настанд зориулж "УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛБӨ" сургалт зохион байгуулсан. Мөн 2023 оны 6 дугаар сард өвлөн тээгч, Ардын авьяастан Ч.Орломжавын контент нэвтрүүлэг бэлтгэн цахимд байршуулан 8800 хүнд хүрсэн. Орхон сумын Соёлын төв ахмад настанруу чиглэсэн Ахмадын баяр, Залгамж тоглолт, Ахмад ажилчдаа жил бүр хүлээж авдаг бөгөөд Сум орон нутгийнхаа ахмад настанд чиглэн үйл ажиллагаа бүрийн араас нийтийн цэнгээнт бужиг зохион байгуулдаг. 2023 оны байдлаар нийт 1142 ахмад нарт үйлчилгээ үзүүлсэн байна. сумын Соёлын төв нь 2 арга хэмжээ зохион байгуулж 158 ахмад иргэдийг хамруулсан. арга хэмжээнд 2057 ахмадыг хамруулсан.</p>	Хонгор Нийт 9
19			Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан арга хэмжээний тоо	Сургалт-3 Арга хэмжээ-10	ХБИ-2, Хилийн чанадад амьдарч байгаа монголчуудад чиглэсэн арга хэмжээ-2	<p>Аймгийн Соёл, урлагийн газар: Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд зориулж 7 арга хэмжээг зохион байгуулж 513 хүнийг хамруулсан. Төв номын сан: Зорилтот бүлгийн 500 иргэдэд 750 боть номоор үйлчилж үнэ төлбөргүй 290 карт нээлээ. Хүүхдийн номын ордон: Ахмад 14, хөгжлийн бэрхшээлтэй 35, тусгаарлах байрны 12 уншигчдад үнэ төлбөргүй карт нээж зөөврийн номын сангаар 6 удаа 150 боть ном, 5 уншигчдад гэрээр ном олгох 11 удаа 19 боть ном хүргэлээ. Шарын гол сумын Соёлын төв: 5 арга хэмжээг зохион байгуулж 48 тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг хүргэсэн. Дарханы Зураач урчуудын эвлэл: 1 арга хэмжээг зохион байгуулж 12 хүүхдийг хамруулсан. Музей: Зорилто бүлгийн иргэдийг аймгийн музейтэй танилцуулах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрэл зургийн үзэсгэлэн үзүүлэх зэрэг нийтдээ 7 арга хэмжээг зохион байгуулж 350 иргэдийг хамрууллаа. Залуучууд театр: Нийт 11 арга хэмжээг 31 удаа зохион байгуулж 2126 хүнийг хамруулсан. Нийт 33 арга хэмжээнд 3615 зорилтот бүлгийн иргэдэд үйлчилсэн.</p>	

20			Иргэдийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэхээр зохион байгуулсан нөлөөллийн аяны тоо	1	6-аас доошгүй нөлөөллийн аян зохион байгуулах	Соёл, урлагийн газар, харьяа Соёлын байгууллагууд нийт 11 төрлийн аянд нэгдэн ажилласан. Үүнд: -“Соёлын сэргэлт” аян, “Соёлын бүтээлч сар аян, “Олуулаа уншъя” аян, “Нийгэмд шударга ёсыг бэхжүүлье! Хүүхдийн хөдөлмөрийг устга!”, “Харилцан бие биенээ хүндэтгэг”, “Хүндлэл хамгийн тод гэрэл” аян, “Анзаар” аян, Сайн үйлсийн аян, “Намайг алгас” аян, Авлигын эсрэг таслан зогсооё аян, “Нийгэм соёл, төлөвшлийн төлөө” аян, “Хамтаар амьдрах” соёл зэрэг аянуудад тус тус нэгдэн нөлөөллийн ажлыг хийж цахимд байршуулсан.	100%
21	1.1.14 1.2.1, 1.3.8, 1.4.6, 1.5.1, 1.5.2	Үйл ажиллагаа 4.2 Нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх, “Хүүхдэд ээлтэй Монгол” хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний чуулганы зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр бүх шатны байгууллага, иргэдийг уриалсан нөлөөллийн аяныг зохион байгуулах	Нийгмийн соёл гэгээрлийг дээшлүүлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлэг, контент, тоглоом, хэвлэмэл бүтээл, уран бүтээлийн тоо	59	60-аас доошгүй бүтээл бэлтгэж, түгээсэн байх	1.“Цахим-Дархан” төслийн хүрээнд “Маамуу” брэндтэй хамтран Дархан хотын бэлгэдэл баатар бүтээх 2 ангит хүүхдийн анимэйшн контент, хүүхэддэйн кино бүтээх ажлын хэсэгт ажиллаж байна. ОНТ-өөс 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. 2.Сар шинийн баярыг угтан RGB телевизтэй хамтран соёлын биет бус өвийг өвлөн тээгч нарыг оролцуулсан ярилцлага, контент нэвтрүүлгийг бэлтгэж олон нийтэд хүргэсэн. 3.Шарын гол сумын Соёлын төв сар шинийн теле концертыг цахимаар 9241 хүнд, “Хаврын найраг” контентыг цахимаар 16860 хүнд хүргэсэн байна. 4.“Эрхэмсэг эмэгтэйд хаягласан захидал”-ын уралдаанд шалгарсан захиаг цахимаар түгээж 10996 хүнд хүргэсэн. 5.Урианхай бий биелгээний контент хичээлийг цахимаар түгээж, 1200 хүнд хүргэжээ. 6.6. МҮОНТ-ийн бий биелгээний нэвтрүүлэгт СББӨ-ийн өвлөн уламжлагчдаар оролцуулсан. 7.“Угсаатан бий” төслийн сургалтад хамрагдсан Залуучууд театрын 2 бүжигчний бий биелгээг клипжүүлэн МҮОНРТ -ээр цацуулж, олон нийтийн хүртээл болгосон. 8.Сар шинийн баярт зориулан цэцэрлэгийн багш нарын дунд “Дөрвөн бэрх” телевизийн контентыг Цэц.мн цахим сайттай хамтран зохион байгуулав. 9. УБ хотноо МҮОНРТ-ийн “Өв түгээ” зорилгот төслийн нээлтэд 3 өвлөн уламжлагч оролцсон. 10.Ахмадын хөгжлийн төвтэй хамтран идээ ундаа зөв засах, зан заншилын тухай үйл ажиллагаанд оролцов. 11.Гэгээн хайрын баярт зориулан Залуучууд Театрын уран бүтээлчдийн “Хайр өөрөө гайхалтай” лайв тоглолтыг page хуудаснаа байршуулж, 3100 үзэгчийн хандалтыг авсан. 12.Залуучууд театр шагайн харвааны талаар нэвтрүүлэг хийж page хуудаснаа байршуулж, 2900 үзэгчдийн хандалт авчээ. Мөн орон нутгийн телевизүүдээр сурталчилсан. Нийт 12 үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн мэдээллийн хэрэгслээр түгээлээ.	95%
22			Хүүхэд хөгжлийн төвтэй, соёлын бүтээлч орон зай бүрдүүлсэн байгууллагын тоо	38	5-аар нэмэгдүүлэх	Соёлын бүтээлч орон зай бүрдүүлсэн байгууллагын тоо-6. Үүнд: -“Өсвөр насны охид хөвгүүдийн ном”-оор ахлах ангийн сурагчдынхаа дунд #challenge эхлүүлж, хэн хамгийн гоё уншсан номын тэмдэглэл хөтлөж өөрт хэрэгтэй мэдээллийг авч чадсан талаар ярилцаж хамтдаа мэдлэгээ тэлж оюундаа хөрөнгө оруулж хөгжихийг уриалж нийт 6 бүлгийн 129 хүүхдүүдийн дунд номыг сонирхон уншсан 11 сурагч номын тэмдэглэл хөтөлсөн. -Монгол бахархал” илтгэлийн уралдааныг ЕБС-ийн 25 сурагчдын дунд зохион байгууллаа. -Номын сангийн уншигч, үйлчлүүлэгчдэдээ зориулан эрүүл мэндийн “АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХАЙРЦАГ” “САНАЛ ХҮСЭЛТ”-ийн хайрцагийг тус тус байршуулан хүүхдэд соёлын орчин бүрдүүлэн ажиллалаа. -Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын бүтээлч орон зайг бүрдүүлэх зорилгоор “Угийн бичиг”, “Даам тоглож сурцгаая” танхим, кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох орчин бүрдүүлж, боловсролын хөтөлбөрийн танхимыг тус тус бүрдүүлэн ажиллаж байна.	98%
23			Монгол хэл, бичгийн хэрэглээний соёлыг төлөвшүүлэхээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	Арга хэмжээг 10-аар нэмэгдүүлэх	-Эх хэлний өдөр”-өөр 21 арга хэмжээнд 508 хүүхэд, цахимаар 8433 хүнд, -Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд Эх хэл түүх соёлоо эрхэмлэн дээдэлсэн, эрүүл чийрэг, эх оронч, бүтээлч Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд чиглэсэн 22 арга хэмжээг зохион байгуулсан байна. Тэдгээрт нийт 8545 хүүхдийг хамруулсан. - “Хос бичигтэн” арга хэмжээний хүрээнд үндэсний бичиг үсгээ сурч эзэмшин түгээн дэлгэрүүлэх олон талт сургалт, үзэсгэлэн, нөлөөллийн 17 арга хэмжээнд 1092 иргэд олон нийтийг хамруулан зохион байгуулж, дэмжиж ажилласан. Монгол бичгийн цахим болон танхимын 22 сургалтад 423 хүнийг хамруулсан байна. - Монгол бичгийн цахим болон танхимын 22 сургалтад 423 хүн хамрагдсан байна. Хос бичигтэн байгууллага” хөтөлбөрийг сурталчилсан 126 зурагт хуудас, контентыг бэлтгэн цахим сүлжээнд байршуулж иргэд олон нийтэд сурталчиллаа. G32- Соёл, урлагийн газар болон харьяа байгууллагууд нийт 22 албан бичиг, 8 албан хаагчийн нэрийн хуудас, ажлын үнэмлэх, байгууллагын хаягийг монгол бичгээр үйлдэж хэрэглээнд нэвтрүүлээ.	100%

24
25

<p>Монгол хэл, бичгийн нийтийн хэрэглээний орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо</p>	<p>10</p>	<p>Арга хэмжээг 10-оор нэмэгдүүлэх</p>	<p>-Харьяа номын сангуудтай хамтран үндэсний бичиг, үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд "Бийрэн бичлэг", "уран уншлага"-ын сургалт, уралдааныг 16 удаа зохион байгуулж 158 иргэнийг хамруулсан. -"Бийрээ нийлье" үндэсний бичгийн уралдаанд 105 сурагчийг хамруулсан. -СББӨ-ийн өвлөн уламжлагч, 30 дугаар сургуулийн менежер Ж.Эрхэмсайхан багшийн Монгол хэл бичгийн түүхт судар, Хуйлмал ном, Монгол уран бичлэг, уламжлалт ном бүтээх урлалаар видео контент хийж цахимд байршуулж 2250 хүнд хүргэлээ. -Монгол бичгийн цахим бичвэр, түргэн уншлагын уралдаанд 45 албан хаагчийг хамруулсан. -Монгол бичиг анхлан суралцаж буй ЕБ –ын 2,6 дугаар сургуулийн 6 дугаар ангийн 56 хүүхдийн дунд танин мэдэхүйн "АХА" тэмцээн зохион байгуулсан. -Иргэдийн эх хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор цахимаар 3 удаагийн нийтлэл оруулж, 1045 хүнд хүргэсэн. Нийт 10 арга хэмжээ зохион байгуулж 364 иргэдийг хамруулж цахимаар 3295 хүнд хүргэлээ.</p>	<p>95%</p>
<p>Соёлын биет бус өвийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>30</p>	<p>10-аар нэмэгдүүлэх</p>	<p>Тайлант хугацаанд Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих, тоглолт, шавь сургалт зохион байгуулах, сурталчлах, алдаршуулах чиглэлээр нийт 22 арга хэмжээг зохион байгуулж 1115 хүн хамрагдсан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2023.02.15-ны өдөр "Өв соёл - Цагаан сар" уулзалт, хэлэлцүүлгийг Ахмадын хөгжлийн төвд зохион байгуулж 32 хүн хамрагдлаа. 2023.03.27-ны өдөр "Дархан тайж Хасарын нэрэмжит төвийн бүсийн аварга шалгаруулах үзэсгэлэн тэмцээн"-ийг Дархан хотноо анх удаа зохион байгуулж 8 ангилалд 71 Монгол банхар ноход өрсөлдлөө. Үзэгчдийн тоо 150 УБ хотноо МҮОНРТ-ийн "Өв түгээ" зорилгот төслийн нээлтэд аймгийн 3 өвлөн уламжлагч оролцсон. Хонгор сумын СББӨ-ийг өвлөн уламжлагч 3 иргэн "Олон улсын музейн өдөр" буюу 2023.05.18-нд өөрсдийн өвлөсөн өвөөр мэндчилгээ дэвшүүлсэн. Орхон сумын СББӨ-ийн 3 үеийн өвлөн уламжлагчид болон тус сумын Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сурагчдын хамтарсан гурван үеийн "ЗАЛГАМЖ" тоглолыг сумын 300 иргэнд толилуулсан. Бий биелээч 17 хүүхэд Хүүхдийн баярын нээлтэд биеллээ. Шарын гол сумын ЕБС-ийн бага ангийн 300 сурагчдын дунд "Зан заншлаас суралцья" уралдаан, номын санч уран уншлагын дугуйлангаар дамжуулан долоон насанд хүрэгч 31 хүүхдэд ерөөл, магтаал аялгуулан уншихыг зааж сургасан. Ахмад уран бүтээлч бий биелгээний сургалтад хамрагдан төгсөөд 12 хүүхдэд бий биелгээ, 2 хүүхдэд хурдан морины цол дуудах эрдэмд сургасан. Тус аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг нэмэгдүүлэх, шавь сургалтыг уламжлал болгох зорилгоор "Өв соёлоо өвлөн уламжилъя" Зүү ороох хатгамлын сургалтад ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 20 сурагчийг хамруулан зохион байгуулсан. СББӨ-ийг өвлөн уламжлагч нийт 7 хүнийг "АРДЫН АБЪЯАСТАН" цол тэмдэгт тодорхойлж шагнаж урамшуулсан. Хонгор сумын Соёлын төв нь "Соёлын сэргэлт 2023" аяны хүрээнд СББӨ-ийн өвлөн уламжлагч 7 иргэний танилцуулга мэдээллээр Дархан-Уул аймгийн Залуучууд театрт үзэсгэлэн гаргаж алдаршуулсан. "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд СББӨ-ийн өвлөн уламжлагч 4 ахмад иргэний танилцуулга видеог цахимд байршуулсан бөгөөд нийт 3509 хүн үзэж 378 хүнд таалагдаж 103 сэтгэгдэл үлдээж 47 хүн хуваалцсан байна. Хонгор сумын малчин иргэдийн дунд Гавлиу хайрханы тахилгыг тохиолдуулан "Магчдын баяр"-ын арга хэмжээг 2023.06.27-28 өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус баярыг хүрээнд 15 багийн 150 гаруй иргэд Шилмэл малын үзэсгэлэн, Сээр цохих тэмцээн, Сураар бүтээгдэхүүн хийх, Дээс томох, Цагаан идээ шалгаруулах, Олс татах, Хос морьтон шалгаруулах, Шагай шүүрэх, Эмнэг булгиулах Хурдан морины барилдаан, Үндэсний бөхийн барилдаан зэрэг төрлүүдээр өрсөлдсөн. ЕБС-ийн 2 дугаар сургуулийн бага ангийн сурагчдын дунд "Зан заншлаас суралцья" уралдааныг хамтран зохион байгуулсан. Номын санч уран уншлагын дугуйлангаар дамжуулан 7 насанд хүрэгч, 31 хүүхдэд ерөөл, магтаал аялгуулан уншихыг, 2 хүүхдэд хурдан морины цол дуудахыг зааж сургасан. Шарын гол сумын Соёлын төв өвлөн уламжлагч, соёлын ахмад ажилтан Цэрэнжавтай хамтран ажиллах гэрээ байгуулан, морин хуурын дугуйлан хичээллүүлсэн. Ахмад СББӨ-ийн өвлөн уламжлагч З.Алтанцэцэгийн УИХ-ын гишүүн Б.Баттөмөрийн ивээл дор зохион байгуулагдсан бий биелгээний сургалтыг ЕБС-ийн 25 сурагчдад зааж сургасан. "Нүүдэлчин Монгол" дэлхийн фестивальд тус аймгаас СББӨ-ийн 15 өвлөн уламжлагчид СББӨ-ийн 6 төлрөөр иргэдэд өв соёлоо сурталчлан оролцлоо. Орхон аймгийн Соёлын төв СББӨ-ийн өвлөн уламжлагчид болон дугуйлангийн сурагчдын хамтарсан "Залгамж" тоглолыг толилуулж 300 иргэнд хүргэсэн. 	<p>100%</p>

26	1.1.7, 1.3.7, 1.4.3, 1.4.4, 1.4.8, 1.5.3, 1.5.7,	Үйл ажиллагаа 4.3 Соёлын өвийн боловсролыг өвлөн уламжлуулж, түгээн дэлгэрүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулах	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах	8	5-аар нэмэгдүүлэх	<p>1. Сяньбигийн үеийн хаад язгууртны 2, 9, 10, 11 дугаартай бунхат булшны малтлагын ажил 2022-2023 онуудад хийгдэж Хонгор сумын Засаг даргын Тамгын газраас хашаа хийж хамгаалтад авч ойролцоо байдаг малчин айлтай гэрээ хийж хамгаалуулсан байна.</p> <p>2. Хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал алдагдсан соёлын биет өвийн судалгаагаар хууль бус эрсдэлд өртсөн булш, оршуулгын дурсгал тоногдсон 2, орон нутгийн чанартай замд өртсөн 2, байгалийн хүчин зүйлийн нөлөөлөлд өртөж эх төрх байдал нь алдагдсан 1, хагарч хугарсан 1 ширхэг соёлын үл хөдлөх дурсгалт өв байна.</p> <p>4. Хонгор сумын нутаг дэвсгэр дээр оршдог улсын хамгаалтад байдаг "Хүйтэний голын бичээст хад", аймгийн хамгаалтад байдаг "Ногоон толгойн хиргэсүүр", "Чингисийн морины уяа", Хүйтний хурлын туурь, "Суваргатай хад" бүхий нийт 23 үл хөдлөх дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулан тус сумын гурван байгаль хамгаалагчид хариуцуулан харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд харуул хамгаалтад авах ажлыг зохион байгууллаа.</p> <p>5. Хонгор сумын газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастр зурганд түүх соёлын үл хөдлөх дурсгалт 23 газрын координатын тэмдэглэгээг оруулах ажлыг зохион байгууллаа.</p> <p>6. Орхон сумын нутаг дэвсгэрт байрладаг түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл тооллогоор тоологдсон 5 дурсгалт газрыг ойролцоо нутагладаг 3 малчин иргэнд гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалууллаа.</p> <p>7. "Найрамдал" төслөөс санаачлан "Metaforce" компанитай хамтран Дархан-Уул аймгаас олдсон Сяньбигийн үеийн хаад язгууртны бунхант булшуудын олдворууд, "Домогт Шарын гол компанийн ой, Хүйтэн голын Бичигт хад, Нүүдлийн соёл иргэншил, түүх соёлын дурсгалуудыг 3D-гээр үзүүлэх кино контент бүтээхэд хамтарч ажилласан.</p> <p>Орхон сумын түүх дурсгалын үл хөдлөх 5 дурсгалт газрыг 3 малчин иргэнд, гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулсан. Хонгор сумын 23 үл хөдлөх дурсгалт газрыг харьяа нутаг дэвсгэрийн 3 байгаль хамгаалагчид гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулж, сумын Газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастрын зурганд тэмдэглэгээ хийлгэлээ.</p>	100%
27			Түүх, соёлын хөдлөх дурсгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах	86	20-оор нэмэгдүүлэх	<p>1."Хөшөө дурсгалаа хамгаалах" дэлхийн өдрийг тохиолдуулан аймгийн Музейгээс Орхон сумын Соёлын Төвтэй хамтран 2018 онд босгосон Морь барианы газрын морины хөшөөг цэвэрлэн, угааж өнгөлж сайжруулав.</p> <p>2.Залуучууд театр "Аавын гутал" хөшөөг цэвэрлэн өнгөлж ойр орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэн тохижилт үйлчилгээ хийсэн.</p> <p>3.СӨҮТ-өөс ирсэн албан бичгийн дагуу авдар, хул аяга, морин хуур 3 үзмэрийг сэргээн засварлуулахаар хүргэж ажиллав.</p> <p>4. 37 дэсийн 39 ширхэг уран зургийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор СӨҮТ-д сэргээн засварлуулах саналыг албан бичгийн хамт илгээв.</p> <p>5.Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан "Практикал" даатгалд уужтай эхнэр дээл, хүрмэн тэрмэн дээл, эхнэр дээл гэсэн 3 дэсийн 3 ширхэг үзмэрийг даатгуулав.</p> <p>6.Сан хөмрөгт хадгалагдаж багаа 358 дэсийн 518 гэрэл зургуудийг цахимд шилжүүлэн цахим архив үүсгэн хадгалах ажлыг 40 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>7.Музейн Байгаль, Түүх, Угсаатан, Найрамдлын 4 танхимд үзмэрийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг Дархан ариутгал ХХК-иар хийлгэж, үзмэр эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулав.</p> <p>8. Музейн үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор үзмэр зөөж тээвэрлэхэд аюулгүй ажиллагааг хангаж хадгалалтын 3 ширхэг модон хайрцаг хийлгэсэн.</p> <p>9.Шарын гол сумын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дүгээр тушаалаар баталсан "Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох "Буган чулуун хөшөө"-г 2 дугаар сургуулийн Г.Отонжаргал багштай анги хамт олон ойр орчмын хогыг цэвэрлэж, хашааг будаж өнгийг сэргээсэн.</p> <p>10.Аймгийн Музейд хадгалагдаж буй МУСГЗ, нэрт зураач Н.Цүлтэмийн "Уулзалт" уран зургийг судалж түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэр дэвшүүлсэн.</p> <p>2023 оны IV дүгээр улиралд Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын бэлтгэл ажлыг гүйцэтгэв. Бэлтгэл ажлын хүрээнд Дархан, Хонгор, Орхон сумын музей хамрагдаж 62 дэсийн 70 ширхэг үзмэрийг Register программ, музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн дэвтэрт бүртгэж бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.</p> <p>Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Хонгор, Орхон сумын музейн ажилтнуудад нь үзмэртэй харьцах, үзмэр зөөж тээвэрлэх хадгалалт хамгаалалтын талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>Тайлант хугацаанд 2 үл хөдлөх түүх соёлын дурсгалт хөшөө, Музейн 3 үзмэрийн гадаад өнгө төрхийг сэргээн засварласан. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа 358 дэсийн 518 гэрэл зургуудийг цахимд шилжүүлэн цахим архив үүсгэн хадгалах ажлыг 40 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн.</p>	100%

28			Баримтат өвийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах	3	2-оор нэмэгдүүлэх	<p>Хагас жилийн байдлаар иргэдийн гар дээр байсан 27 баримтад өвийг бүртгэл судалгаанд хамруулж хадгалалт хамгаалалтын талаар зөвлөгөө өгч ажилласан байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар: 1. Дархан-Уул аймгийн Дархан сум 5-р баг Гэцогдаржайлин хийдэд хадгалагдаж байгаа Богд ламын чуулганы орон-цогшин, Ногоон дара эх, Заяаны таван тэнгэр, Лагшин /бие/ зарлиг /хэл/, таалал /сэтгэл/-ын шүтээн, Хараагийн дарь эхийн түүхэн уран зураг, Нархажид бурхан, Соёмбо үсгийн зээгт наамал, Хутагт хувилгаадын гэрэл зураг, шавар бурхан барласан дардас, зурмал бурхан, судар, монгол зураг танка зураг зээгт наамал нийт 9 дэсийн 9 ширхэг; 2. Дархан сумын 4 дүгээр багын иргэн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч О.Туулд өвлөгдөж ирсэн Говийн Лха бурхан, зөвшөөрлийн бичиг 2 дэсийн 2 ширхэг 3. Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 12 дэсийн 12 ширхэг баримтад өв бүртгэлд хамрууллаа. Тайлант хугацаанд Дархан-Уул аймгийн харьяат 4 иргэний гэрт хадгалагдаж буй 29, Гэцогдаржайлин хийдийн 9, Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 12, нийт 50 дэсийн 51 ширхэг соёлын баримтат өвийг бүртгэл судалгаанд хамруулан баримтжуулсан.</p>	100%
29			Хүүхэд багачуудад зориулсан нүүдэлчдийн язгуур урлагийн арга хэмжээ зохион байгуулах	Зохиогдсон арга хэмжээний тоо - 2	7-аар нэмэгдүүлэх	<p>Наадам, тоглолт: 1. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд Язгуур урлагийн тоглолтод 14 хүүхэд оролцож Гийнгоо, ерөөл магтаал, бий биелгээгээр оролцож "Шилдэг аймаг"-ийн нэгээр шалгарсан. 2. Орхон сумын Соёлын төв нь СББӨ-ийн өвлөн уламжлагчид болон тус сумын Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сургагчдын хамтарсан гурван үеийн "ЗАЛГАМЖ" тоглолтыг сумын 300 иргэнд толилуулсан. 3. Казак үндэсний баярыг тохиолдуулан Наурызын баярыг Хонгор суманд Казак ард түмний ёс заншлыг суртчилах зорилгоор "Казак гэр" наадмыг зохион байгуулж 150 гаруй хүүхэд хамрагдав. 4. Залуучууд театрын хөгжимчин МУСТА Н.Нямбаатар, Л.Уянга нарын хамтарсан "Аядуун" язгуур тоглолтыг зорилтот бүлгийн 50 гаруй хүүхдийг хамруулсан. 5. Хүүхдийн язгуур урлагийн бэсрэг наадам"-д тус аймгаас уран нугаралтын өвөөр 4 сурагч амжилттай оролцлоо. 6. МҮОНРТ-ээс зохион байгуулсан "Өв түгээ" төслийн нээлтэд СББӨ-ийн 1 өвлөн уламжлагч хүүхэд, 7. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нээлтэд бий биелээч 17 хүүхэд, 8. Олон улсын Музейн өдрийн нээлтэд 2 өвлөн уламжлагч хүүхэд, 9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн нээлтэд 2 өвлөн уламжлагч хүүхэд, 10. "Уран үйл 2023" төвийн бүсийн уралдааны нээлтэд 1 өвлөн уламжлагч хүүхэд тус тус оролцлоо. Уралдаан тэмцэн: 11. "Зан заншлаас суралцаж" ерөөл, магтаалын уралдааныг зохион байгуулсан. Тус уралдаан 300 сурагч оролцлоо. 12. "Darkhan dance festival" анхдугаар бүжгийн уралдааны Язгуур урлагийн төрөлд 18 багийн 300 гаруй сурагч оролцсон. Сургалт: 13. МУУГЗ Г.Баяртай багшийн "Угсаатан бий" төслийн хүрээнд 15 хоногийн 6 угсаатны бий биелгээний сургалтыг зохион байгуулж сургалтад нийт 17 хүүхэд хамрагдаж тайлан тоглолт хийсэн. 14. Зулзага хүүхдийн зусланд амрагч хүүхдүүдэд зориулсан бий биелгээний сургалтыг 3 удаа зохион байгуулж 450 хүүхэд, 15. Ерөөл, магтаалыг өвлүүлэн уламжлах сургалтад 31 хүүхэд, 16. Сумын Соёлын төвд бий биелгээний сургалтад 12 хүүхэд 17. Хурдан морины цол дуудах сургалтад 2 хүүхдийг тус тус хамрууллаа. Контент, нэвтрүүлэг, цахимаар: 18. Шагайн харвааны нэвтрүүлэг-2900 19. RGB телевизтэй хамтран СББӨ-ийн өвлөн уламжлагчид, хүүхдийн язгуур тоглолт, ярилцлага 20. Угсаатан бий" төсөлд хамрагдсан СББӨ-ийн 17 хүүхдийн оролцсон тайлан тоглолт 21. Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвүүд нь нийт 8 өвлөн уламжлагчийн танилцуулгыг бэлтгэж цахим сүлжээгээр иргэд, олон нийтэд сурталчилсан.</p>	90%
30			Дуу хөгжим, тайзны урлагийн мэдлэг ойлголтыг өгөхөөр зохион байгуулсан арга хэмжээний тоо	39	10-аар нэмэгдүүлэх	<p>1. Залуучууд театрын үйл ажиллагаа, мэргэжлийн дуу, бүжиг, хөгжим, драмын ангийн танилцуулга мэргэжил үйл ажиллагааг сурталчих хүрээнд: 2. Соёл, урлагийн салбарын ажилтны өдрийг угтан 3 сумдын Соёлын төвийн албан хаагчдад 3. Соёлын Сайд Ч.Номин "Соёлын сэргэлт-2023" аяны нээлтийн айлчлал, 4. ЕБС-ийн ахлах ангийн 400 гаруй сурагчдад тус тус зохион байгууллаа. 5. "Darkhan dance festival" анхдугаар бүжгийн уралдааныг зохион байгуулахад /Дархан сумын ЗДТТ-аас 5.5 сая төгрөг/, уралдаанд 18 багийн 300 гаруй сурагч оролцсон.</p>	

31		Үйл ажиллагаа 4.4 Иргэдийн урлагийн боловсролыг дээшлүүлэх, сурталчилгаа, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулах	Кино, контент, дүрсний урлагийн боловсрол, шүүмж сэтгэлгээг хөгжүүлэхээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	8	3-аар нэмэгдүүлэх	<p>-Соёлын сэргэлт аяны хүрээнд "Кинонд ээлтэй Дархан" уриан дор "ОРЛОН ТОГЛОГЧ" бэлтгэх сургалтыг аймгийн ЗДТГ-ын спорт зааланд зохион байгууллаа. Тус сургалтад 13 оролцогч хамрагдав.</p> <p>-Кино зохиолын туурвил зүйг сургалтад 31 хүн, Кино урлагаар үндэсний соёлын дархлааг сэргээх нь" илтгэлийг Хонгор, Орхон сумын соёлын төвд зохион байгуулж 310 хүнийг тус тус хамруулсан.</p> <p>-Кино үдэш арга хэмжээ болон Монгол кино ба Дархан хот үзэсгэлэнг тус тус зохион байгуулсан.</p> <p>-"Кинонд ээлтэй Дархан" форумыг зохион байгуулсан.</p> <p>-Киноны хөгжмүүдээр "Анир" поп оркестр бүрэн хэмжээний тоглолтыг тоглож Монгол кино нэгтгэл Кино үзэсгэлэнг дэглэв.</p> <p>-Кино соёлыг сурталчилах хүрээнд "Машинтай кино үзвэр"-ийг 2 удаа зохион байгууллаа.</p> <p>-"Соёлын түүчээ 330" төслийн хүрээнд Шарын гол, Орхон, Хонгор сумдад 6 киног 25 удаа-1426 үзэгч, бусад байгууллагын 19 киног 29 удаа-3266 үзэгч, Залуучууд театрт 12 киног 72 удаа-14653 үзэгчдэд тус тус үзүүлсэн.</p> <p>-Хархорум олон улсын кино наадмын "Киног олон улсын кино наадамд бэлтгэх нь" суралгалтад 3 уран бүтээлч оролцож байна.</p> <p>-"Кино нүүдэл" Олон Улсын сургалтад тус аймгаас 5 уран бүтээлч хамрагдаж сертификат авсан.</p> <p>-Соёл, урлагийн боловсрол, шүүмж сэтгэлгээг хөгжүүлэхээр 14 контент бэлтгэн иргэд, олон нийтэд түүгээсэн.</p> <p>- Монгол-Японы хамтарсан олон ангит "Vivant" киноны зураг авалтыг Дархан хотод хийж маскийг 420 хүнээр бүрдүүлсэн.</p> <p>-Зүрхэнд гэрэлтэнэ" МУСК, "Цор ганц" 10 ангит МУСК-ны зураг авалт тус аймагт хийгдэж Залуучууд театрт нээлтээ хийсэн.</p> <p>-"Үлгэрийн ертөнц"-ийн контент, уран бүтээлүүдэд Залуучууд театрын уран бүтээлчид тоглосон.</p> <p>-Нийт 14 арга хэмжээ зохион байгуулсан.</p>	95%
32			Дүрслэх урлаг, дизайн архитектурын мэдрэмжийг хөгжүүлэх үндэсний агуулга бүхий орон зайн хөтөлбөр, төслийн тоо	9	5-аар нэмэгдүүлэх	<p>1."ART FAIR 2023" дүрслэх урлагийн үзэсгэлэн худалдаанд Дарханы Зураач урчуудын эвлэлийн 4 зураач нийт 11 бүтээлээр оролцсон.</p> <p>2.Монголын Уран зургийн галерейтай хамтран "Галерей аялж байна" хөтөлбөрийг Дархан хотын үзэгч олонд 2 өдөр толилуулав. Уг хөтөлбөрийн хүрээнд "Монголын шилдэг уран зургууд" нүүдлийн тусгай үзэсгэлэн, "Хөгжимтэй зураг" хөтөлбөр, "Хандлагаар анагаахуй" урлагийн сэтгэл заслын хөтөлбөр, "Цаг хугацаагаар аялагч" олон нийтийн оролцоот урлагийн бүтээлийг үзэгчдэд толилуулав.</p> <p>3.Улаанбаатар хотноо 2 дахь жилдээ зохион байгуулагдсан Үнэт эдлэл, Соёлын өвийн хосгүй бүтээлүүд, Гоёл чимэглэлийн салбарын нэгдсэн үзэсгэлэнд Дарханы урчууд амжилттай оролцлоо.</p> <p>4.Зураач урчуудын эвлэлийн зураач С.Мөнгөнзулын анхны биеэ даасан "Гүнж" уран зургийн үзэсгэлэн,</p> <p>5.Аймгийн Музейд Хүний эрх, эрх чөлөө" шог зургийн үзэсгэлэн,</p> <p>6."Дархан хотын хөшөө дурсгал-Миний дуранд" гэрэл зургийн үзэсгэлэн,</p> <p>7.Хуримын ордонд "Art of n" хүүхдийн уран зургийн үзэсгэлэн,</p> <p>8.Монголын гэрэл зургийн холбоотой хамтран "Цаг уурын өөрчлөлт" гэрэл зургийн үзэсгэлэн</p> <p>9. "Монгол Арт" Галерейтай хамтран Монголын алдарт зураач, уран бүтээлчдийн бүтээлүүдээр нүүдлийн үзэсгэлэн</p> <p>10.Евро Азийн соёл, урлагийн нийгэмлэг, Монголын урчуудын эвлэлийн удирдах зөвлөлөөс Дарханы зураач урчуудын эвлэлийн залуу уран бүтээлчидтэй уулзаж, цаашдын уран бүтээлийн хамтын ажиллагаа Дархан хотод дүрслэх урлагийг хөгжүүлэх тухай асуудлаар санал бодлоо солилцлоо.</p> <p>11. Аймгийн Музей нь пняз сонирхогч, цуглуулагч нартай хамтран "Хөгжим миний амьдралд" үзэсгэлэнг гаргаж 60 гаруй пняз, 275 үзэгч,</p> <p>12. Дарханы зураач урчуудын 22 уран бүтээлийн "Мэдрэмж" уран зургийн үзэсгэлэн-568 иргэд,</p> <p>Нийт 12 удаагийн үзэсгэлэнг зохион байгуулж соёлын байгууллагууды бүх нийтийн соёлын боловсролд чиглэсэн 22 арга хэмжээнд 8545 хүүхдийг хамрууллаа.</p>	
5		Зорилт 5. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх					
33	1.2.4, 1.2.5, 1.2.6, 1.3.4 1.3.5	Үйл ажиллагаа 5.1 Албан бус соёл, урлагийн боловсролын төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн соёл, урлагийн сургалтын төвүүдийн тоо	12	Дэмжлэг үзүүлсэн сургалтын төвийн тоог 10 аар нэмэгдүүлэх	<p>Дэмжлэг үзүүлсэн соёл, урлагийн байгууллагын тоо-15. Үүнд:</p> <p>-"Хөх тэнгэрийн орон" уран бүтээлийн тоглолтыг шинээр найруулан тавьж, 60 уран бүтээлч оролцон 2 удаа тоглогдож 1182 үзэгч үзсэн. Залуучууд театраас 7.0 сая, АЗДТГ-аас 53,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-МУСТА, дуучин Б.Соронзонболд нь Дархан магтаал, Золгох ерөөгийн дуунуудыг шинэчлэн бүтээсэн уран бүтээлийн зардалд ОНТ-өөс 1.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-"Muuji's dance" клубын багшийг олон улсын бүжгийн тэмцээнд оролцоход Соёл, урлагийн газраас 2 удаагийн дэмжлэг үзүүлж Их британи, Япон улсын элчин сайдын яамдуудад визийн хүсэлт хүргүүлж шийдвэр гаргах түвшинд уламжилсан. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,5 сая, Дархан-Уул аймгаас УИХ-д сонгогдсон гишүүн Б.Жавхлангийн ажлын албанаас 1 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.</p> <p>-Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс "Darkhan dance festival" анхдугаар бүжгийн уралдааныг зохион байгуулахад нь 5,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус тэмцээнд 18 багийн 300 гаруй сурагч оролцсон.</p> <p>-Соёлын байгууллагуудад нийт 30 удаагийн үзэсгэлэн гаргахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.</p> <p>-Харьяа -Аймгийн</p> <p>Засаг даргын нэрэмжит оны шилдэг яруу найрагч шалгаруулах "Гал өд" яруу найргийн наадмыг зохион байгуулахад хамтран ажилласан.</p>	100%

34	Үйл ажиллагаа 5.2 Соёлын боловсролын нийтлэл, нэвтрүүлэг, сурталчилгаа явуулахад хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах	Хамтран ажилласан байгууллагын тоо	32	2-оор нэмэгдүүлэх	<p>Соёлын боловсролын нийтлэл, нэвтрүүлэг, сурталчилгаа явуулахад хэвлэл мэдээллийн 6 байгууллагатай хамтран ажилладаг.</p> <p>-Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизтэй хамтран Музейн сан хөмрөг дэхь уран зураг, уран баримлын тухай "Соёл эрдэнэ" нэвтрүүлэг бэлтгэсэн. Тус нэвтрүүлэг 2023 оны 10 дугаар сарын 7-нд цацагдсан.</p> <p>-Соёлын боловсролын нэвтрүүлэг, контентийг Цэц.мн, ДиБиЭс, RGB, FM104,5, ABC online TV зэрэг 5 хэвлэл мэдээллийн байгууллагаар 10 удаа гарсан.</p> <p>-Шидэт модны үр хүхдийн жүжгийг видео контент болгож орон нутгийн DBS, RGB телевизүүдээр гаргасан.</p> <p>-RGB телевизтэй хамтран соёлын биет бус өвийг өвлөн тээгч нарыг оролцуулсан ярилцлага, контент нэвтрүүлэг бэлтгэсэн.</p>	100%
----	---	------------------------------------	----	-------------------	---	------

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН: СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ДОЛГОРМАА

